

НИШИДА КИТАРОГИЙН ФИЛОСОФИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Д.ОЮУНГЭРЭЛ - ХААИС-ийн багш, МУИС-ийн докторант

Товч утга. Н.Китарогийн философи нь өөрийн гэсэн ойлголтуудтай, түүнийхээ хүрээнд үзэл баримтлалаа илэрхийлсэн өвөрмөц философи байдаг.

Дорно дахины философи нь үүссэн цагаасаа эхлэн хүний амьдралын философи байсан бөгөөд эдүгээгийн нэг жишээ бол Н.Китарогийн философи бөгөөд түүний философийн гол ойлголтуудын цаад санаа нь хүн, түүний мөн чанар, хүний амьдралын зорилго болон хүний бүх талын хөгжлийн асуудлууд байдаг юм.

Түлхүүр үг: “*башо*” (*basho*), “*цэвэр туршлага*” (*pure experience*), *оршихуй*, *эс оршихуй*, “*үнэмлэхүй эс оршихуй*” (*absolute nothingness*), *хүний ахуй*, *сайн* (*good*).

1920-1930-аад оны Японд өрнийн философи дэлгэрч байсан нөхцөлд Нишидагийн философийн үзэл санаа төлөвшжээ. Түүний философийн үзэл санааны эх сурвалж нь нэг талаас зэн-буддизм, нөгөө талаас өрнийн иррациональ философийн үзлүүд байдаг. Марксизмын үзэл санааны эсрэг тэмцэлд Нишида идэвхитэй оролцсон бөгөөд тэрээр Фихте, А.Бергсон, М.Хайдеггер зэрэг философчдын философийн өвийг судалж Японд дэлгэрүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулжээ. Мөн түүнчлэн Нишида европын философи, логик хоёр универсаль шинжтэй хэмээн тайлбарлаж байв. Тэгэхдээ универсаль шинж бол зөвхөн Европын философийн шинж биш. Бас дорно дахины сэтгэлгээний арга ч универсаль шинжтэй гэдгийг тэрээр онцлон тэмдэглэсэн буй. Нишида дорнын ч биш, өрнийн ч биш, дэлхийн шинэ универсаль философийг бүтээхийг эрмэлзэж байжээ. Нишидагийн философи нь улс төр, соёл, үзэл суртлын салбарт янз бүрийн онол үүсэх үзэл санааны суурь нь болжээ. Одоо түүний иррациональ философийн үндсэн ойлголтуудын агуулгыг авч үзье.

“БАШО” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТ

Нишида Китарогийн философийн гол ойлголтын нэг бол башо (*basho*) гэдэг ойлголт юм. Хэл шинжлэлийн хувьд башо гэдэг нь япон хэлний байр суурь, газар, байх гэсэн утгатай үг ажээ. Гэхдээ энэ ойлголт нь бидний ойлгож буй ердийн ахуй, орших, байхыг тэмдэглэхээс өөр утга агуулдаг. Тэрээр энэ ойлголтоо үнэнхүү универсаль, трансцендент “байр суурь” гэж тодорхойлжээ. Энэхүү ойлголтын гол утга санаа нь хүний ахуйн тухай асуудал гэж ойлгож болох юм.

Киото Их Сургуулийн философийн профессор Косаке Мōсаки Нишидагийн философи дахь башо хэмээх ойлголтыг тайлбарлахдаа “Энэ башо гэдэг ойлголт нь “*ахуйн башо*”, “*харьцангуй хоосны башо*”, “*үнэмлэхүй хоосны башо*” гэсэн гурван төрлийг агуулдаг”⁵¹ гэжээ.

“Ахуйн башо” нь орон зай дахь бүх юмсын оршихуйн үндэс юм. Ертөнцийн бүх юмс үзэгдэл тодорхой байр эзэлж орших ёстой учраас тэдний оршихуйн суурь нь “ахуйн башо” байх бөгөөд түүнээс бүх зүйл шалтгаалдаг. Гэвч “ахуйн башо”-гийн үндэс болдог үл үзэгдэх өөр башо болох “харьцангуй хоосны башо” гэж байдаг. Тэр нь зөвхөн “ахуйн башо”-тай харилцахад бий болдог тул “ахуйн башо”-гоор энэ ойлголтын нэр тайлбарлагдана.

⁵¹ Великие мыслители востока. М., 1999. Стр., 456

Гагцхүү “башо”-гийн төрлүүд дотроос гуравдахь төрөл болох “үнэмлэхүй хоосны башо” л универсаль шинжтэй байдаг тул хүн өөрийн жинхэнэ мөн чанараа ухаарах, түүнийгээ нээж олох газар (байр) нь ажээ. Ингэхлээр “башо” болох “би” үнэмлэхүй зөрчилт ертөнцийн бүх юмстай өөрийгөө адилсгадаг байна⁵²

Нишида өөрийн философидоо “башо” гэдэг ойлголтыг бий болгож түүнийгээ Японы философид нэвтрүүлснээр барууны орнуудад мистик ёсонд хамруулж зуршсан хүний туршлагын үл танигдах зүйлийг тодорхойлоход зориулсан философийн үзлийг боловсруулжээ. Нишида Китарогийн философийн үндсэн ойлголтуудын нэг болох башо нь түүний өөрийнх нь хэрэглэсэн агуулгаар авч үзвэл дараах онцлогтой. Үүнд:

Нэгдүгээрт, тэрээр ахуй ба оршихуйн тухай асуудлыг тодорхойлох зорилт тавьсан байна. Учир нь “Философид ахуй, оршихуйн тухай асуудал үндсэн асуудал байх болно”⁵³ гэж үзсэн байдаг.

Хоёрдугаарт, “башо” гэдэг ойлголтыг ахуйн тухай сонгодог философийн тайлбарлалуудтай холбож үзэхээсээ илүү иррациональ философи дахь хүний оршихуйн асуудлуудтай холбон тайлбарлах боломжтой үндэслэлүүд бий бөгөөд түүний үзлийг иррациональ философи тэр дундаа экзистенциалист философи баримтлалтай харьцуулан авч үзэх бололцоотой.

Гуравдугаарт, мөн башо хэмээх ойлголт нь буддын философийн хоосон чанарын тухай сургаалийн зарим нэг үндэслэлүүдтэй ойролцоо агуулгатай байдаг. Нишида Китаро философи үзлийнхээ хувьд Дорнын философийн сэтгэлгээний уламжлалыг Өрнөдийн философийн хөгжлийн тухайн үеийн ололтуудаар баяжуулж, өөрийн гэсэн философийн систем бий болгож чадсан.

Нишида “философи нь хүнтэй шууд холбогддоогоороо шинжлэх ухаанаас ялгагддаг”⁵⁴ гэж үзсэнээрээ Германы экзистенциалист философич М.Хайдеггерийн философи үзэлтэй адил төсөөтэй байдаг. Философи сэтгэлгээ нь түүний хувьд юуны өмнө интуитив тайлбар уран зохиолын дүрслэн бодохуй герменевтик тайлбар ахуйн утга санааны лавлагаа байсан юм. Түүний үзлээр “сэтгэлгээ бол үнэн бодитой ганц ахуй (башо)-д тэмүүлж байх ёстой” хэмээжээ.

“ҮНЭМЛЭХҮЙ ЭС ОРШИХУЙ” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТ

“Үнэмлэхүй эс оршихуй” (Absolute nothingness) гэдэг ойлголт Нишидагийн философи дахь бас нэгэн үндсэн ойлголт нь юм. “Тэр нь үнэмлэхүй эс оршихуйн өөрийгөө тодорхойлох үйл явцыг бүрдүүлж байдаг бүх юмс үзэгдлийг тодорхойлдог”⁵⁵ гэжээ. Нишидагийн үзэж байснаар “эс оршихуй” хэмээх ойлголт нь “цэвэр туршлагын” ойлголтод хамаатай, субъект, объект үүсч буй газрын бүх байдлыг тэмдэглэдэг байна. Харин ухамсрын агуулга өөрийгөө тодорхойлох буюу өөрийгөө зааглах замаар тодорхойлогддог. Тийм байдлаар үнэмлэхүй эс оршихуйн агуулга зөнгийн үндсэн дээр тавигддаг байна. Нишида энэ зөнг “үйлдэгч” гэж

⁵² Великие мыслители востока. М., 1999 стр., 445-499

⁵³ Kitaro Nishida. An inquiry into the Good. London. 1987 p32

⁵⁴ Kitaro Nishida. An inquiry into the Good. London. 1987 p67

⁵⁵ [http://plato.stanford.edu. /Stanford Encyclopedia of Philosophy/]

нэрлэжээ. Юмсыг бясалгана гэдэг тэдний үйлдэл мэтээр тайлбарлагддаг байна. Эндээс үнэмлэхүй эс оршихуйг тодорхойлдог үйлдэгч зөнгийн ойлголт гарч иржээ.

Эс оршихуй бидэнд оршин буй утгаар, оршин байхуйн замаар болоогүй утгаар мэдэгддэг. “Бидэнд ирээдүй бий” гэж ярьдаг боловч энэ бол хариу биш. Яагаад гэвэл ирээдүй хэзээ ч эхэлж чадахгүй.

“ЦЭВЭР ТУРШЛАГА” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТ

Цэвэр туршлагын үндэслэлийн мэдлэгт тулгуурласан ойлголтуудаа Нишида “Сайн үйлийн тухай сургаал” хэмээх бүтээлдээ оруулжээ. Тэрээр “Тэнгэрийн доорхи хүний амьдралын мөн чанар юунд орших вэ? жинхэнэ бодит байдал гэдэг юу вэ?” гэдгийг тайлбарлах зорилго тавьж, “бодит ахуй гэдэг бол ердөө л манай ухамсрын баримт” гэжээ. Түүнийг энэ үзэл санаа нь цэвэр буюу шууд туршлагад хөтөлжээ. Энэ ойлголт түүний бүх философид нь нэвт шингэжээ. Нишида “цэвэр туршлага” гэдэг субъект, объект хоёр нь ялгараагүй нэгэн өгөгдөхүүн гэж үзэж, түүндээ мэдрэмж, санаа зорго, ухамсрыг багтааж байжээ. Нишида “ер нь ухамсрын үзэгдэл материйн үзэгдэл гэдэг туршлагын баримтуудын хоёр төрөл оршдог гэж бодож болно. Уг чанартаа нэг л оршдог. Энэ нь зөвхөн ухамсрын үзэгдэл юм. Материйн үзэгдэл ердөө л хүн бүхэнд нийтлэг байдаг хувиршгүй харилцаа бүхий юмны хийсвэрлэл юм. Ийм учраас тэр нь ердөө л манай ухамсрын үзэгдлийн хэсэг нь мөн. Ухамсар бидний биед биш, харин бие бидний ухамсрын дотор байдаг. Нишида нь Ж.Берклийн “Юмс оршиж байна гэвэл хүртэгдэж байна гэсэн үг” гэдгээс зайлсхийж, жинхэнэ бодит байдал бол ухамсрын үзэгдэл ч гэж, материйн үзэгдэл ч гэж нэрлэж үл болох тийм нэг зүйл юм. Энэ нь бие даасан нэгэн түгээмэл үйл ажиллагаа юм. Эндээс л оршихуй тэнд үйл ажиллагаа болж сэтгэгджээ. Гэхдээ Нишидагийн философи дахь үйл ажиллагаа, эцэстээ “цэвэр туршлага” болж ирдэг ажээ.

Нисидагийн философийн нэг үндсэн ойлголт болох “Цэвэр туршлагын” ойлголт нь Г.Риккертийн философи, А.Бергсоны интуитивизмыг нэгтгэх зорилгоо шийдэх гэсэн оролдлого нь байжээ. Гэвч түүний оролдлого үүгээр дууссангүй. Тэрээр “Би бүр эхнээсээ л бүхнийг гагцхүү бодит байдлын цэвэр туршлага гэдгээр авч үзэж тайлбарлахыг оролджээ. Эхний үед тэрээр Э.Махын зохиолуудыг уншсан авч ойлгогдоогүй юм. Харин ч туршлага байж гэмээнэ бодгаль байна. Туршлага идэвхтэй гэж үзэж, түүнийг Фихтегийн дараа оршиж байсан трансценденталь философитой холбож болох юм гэж үзсэн юм”

Мөн түүнчлэн У.Джемсийн прагматизм Нишидад нөлөөлсөн тухай Японы судлаачид тэмдэглэсэн бий. Цааш нь, Нисида ёс суртахуун-ёс зүйн зорилтоос урган гарсан шашны философидоо “Хүн яаж зөв амьдрах ёстой вэ. ”Амгалан байдлыг хаанаас олж болох вэ? гэдгийг тодорхойлохоор шийджээ.

Нишида өөрийн “Сайн үйлийн тухай сургаал” хэмээх бүтээлдээ орчин үеийн танин мэдэхүйн онолын таамаглалын үндсэн хоёр аргыг тодорхой түвшинд гаргажээ. Тухайлбал, тааварлалын туршлага нь хувь хүний буюу субъектив шинжтэй байдаг бөгөөд энэ нь бусад хувь хүний үзэл бодлоос урган гарч буй төдийгүй түүний зүй зохистой үйл явцыг агуулснаараа мэдлэгийг чиглүүлэх үндэс болдог хэмээн дүгнэжээ. Харин үндсэн хэлбэрийн туршлага нь мэдрэхүйн ба оюун санааны ур чадварыг агуулсан хувь хүний дадлага туршлагыг мөрдөхгүйгээр гадаад ертөнцтэй холбогдож чадахгүй.

Тэрээр “цэвэр туршлага” миний туршлага биш. Энэ нь миний туршлагын үндэс болж, “би” төлөвших үндсийг агуулсан ухамсрын эхний үйл явц юм. Цэвэр туршлага зөнгөөр (интуицээр) хүртэгддэг. Энэ нь субъект, объект заавал байхыг шаарддаг рефлексээс ангижирсан ухамсар юм⁵⁶ гэсэн байна.

⁵⁶ Kitaro Nishida. An inquiry into the Good. London.1987 p3

“Цэвэр туршлага” (pure experience) гэдэг нь зөвхөн гоо зүйн болон оюун санааны туршлагын үндсэн хэлбэр бус, харин үнэн бодит фундаменталь хэлбэрийг шаарддаг “зөвхөн туйлын ганц бодит үнэн” хэмээх өөр хоорондоо нарийн ялгаа бүхий үзэгдлүүдээс үүсэлтэй ойлголт юм. Ойлгох, ухамсарлах, хүртэх, хүсэх болон оюун санааны зөн совин, таамаглал зэрэг танин мэдэхүйн үйл явцууд нь бүгдээрээ цэвэр туршлагын үзүүлэлтүүдийн үүсмэл хэлбэрүүд байдаг боловч үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл зэрэг нь цаг үргэлжид урагшилж байдаг нь тэдний бодит орон зай болдог гэжээ.

Жишээлбэл, уралдааны морьдын шалгаруулалтыг авч үзье. Уралдаж буй морьд тодорхой хугацаанд өөрийн бүхий л чадвараа дайчлан хурдалж, урагш тэмүүлэн давхидаг, энэ үйл явц бидний дэвшүүлээд байгаа урагш тэмүүлэх үзэл бодлын нэг илрэл төдийгүй цэвэр туршлагын туйлын үнэн зүйл бөгөөд дараа дараагийн үзэл бодлын үндэс болох ба нөгөө талаар “Би урагшилж байна” гэсэнтэй ижил юм. Объектив үзэгдэл нь цэвэр туршлага үүсэлтэй бөгөөд тэднийг хамтад нь “байгаль”, “ариун дагшин” хэмээн нэрийдэх нь нэгдмэл үйл явцын нэг илрэл ажээ. Цэвэр туршлага гэдэг нь бодит динамик үйл явцуудын өөр хоорондоо ялгаатай зүйлсийг субъектив ба объектив үзэгдэлд шууд нөлөөллийг бий болгох өндөр төвшин бөгөөд Нишидагийн Сайн үйлийн тухай сургаалын илрэлийн нэг тод жишээ бол аливаад нэгдмэл байр сууринаас хандах явдал байжээ.

“Цэвэр туршлагын” онолоо боловсруулахад Нишидад хамгийн том нөлөө үзүүлсэн хүн бол У. Жеймс, Эрнст Мах нар ажээ. Тэрээр тэдгээр судлаачдын хоорондоо ялгаа бүхий онол баримталуудыг үндэс болгон XX зууны үзэл баримтлал, хувь хүний бүтээлч бодит чанаруудын олон талын төвшинг бий болгох нь зайлшгүй хэрэгтэй болохыг өөрийн онолдоо дэвшүүлэхийг зорьжээ. Бид бүхний нэрлэж байгаа түүний бодит шалгуурын “онол” бол үзэл бодлын нэгэн ургальч санаа бөгөөд онолын хувьд байгалиас уламжлагдан ирсэн нэгдмэл байдлын туршлага үндэслэлүүд ба тэдгээрийн эх сурвалжуудын хоорондох ялгаанаас үүдэлтэй үйл явцын тусгал биш гэдгийг харуулахыг оролджээ.

Нишидагийн цэвэр туршлага (объектив, субъектив туршлагын нэгдэл) хэмээх ойлголтоо өөрөө тайлбарлахдаа ертөнцийг үзэх зөн билэг, урьдаас таамаглах явдал нь оюун санааны нэгэн бодит илрэл гэжээ.

Түүнчлэн Нишидагийн хувьд түүний урьд өмнө нь баримталж байсан ертөнцийг үзэх үзэл нь хувь хүний үүднээс хандах үзэл баримтлал, төсөөлөл нууцлаг хэвээр оршиж байсан боловч хожим нь Гегелийн бодит ертөнцтэй дасан зохицох явдал түүний бүтээлд нөлөөлөхийн зэрэгцээ ертөнцийг өөрийн тодорхойлолтын адилаар хувь хүний яриа хэлцэл мэтээр хожмын бүтээл туурвилдаа тусгажээ.

“САЙН” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТ

Бид өөрсдийн харилцааны талаар аль нь сайн, аль нь муу байгаа талаар байнга үнэлэлт дүгнэлт өгч байдаг. Өрнө болон дорно дахины улсуудад эртнээс ёс суртахууныг судлах, янз бүрээр ангилах зэргээр судалж байсан ба ёс суртахууны талаар олон ухагдахуун, хуулиудыг бий болгож хөгжүүлж ирсэн. Үүний нэг жишээ бол Н.Киторогийн философи дахь сайн гэдэг ойлголт болно. Тэрээр ёс зүйн ойлголтуудыг ерөнхийд нь хоёр бүлэгт хуваасан ба үүнд heteronomous ёс зүй нь хүмүүнлэгээс ангид сайн муугийн тухай стандартыг багтааж байдаг бол нөгөөх нь autonomous ёс зүй бөгөөд энэ нь хүний мөн чанар дээр үндэслэн сайн мууг тогтоож байдаг⁵⁷ гэжээ. [энэ талаар дараа тайлбарлах болно]. Эдгээрээс гадна түүний ёс

⁵⁷ Kitaro Nishida. An inquiry into the Good. London.1987 p103-104

зүйн сургаалд intuitive ёс зүй гэж байдаг. Энэ нь бид гал халуун, мөс хүйтэн гэж мэддэг шиг ямар зан чанар сайн, ямар нь муу гэдгийг төрөлхийн зөн совингоор мэдэж болно гэсэн үг хэмээдэг гээд үүнийгээ тайлбарлахдаа "Сайн муугийн ялгаа нь хувь хүн болгон дээр яригддаг ба үүнд нэгдсэн стандарт ойлголт гэж байхгүй. Хэрэв бид өдөр тутмынхаа үйл ажиллагааг ажиглавал бид сайн мууг ялгахдаа бодож боловсруулалгүйгээр сайн мууг ялгаж байдаг. Бидний нүд үзэсгэлэн гоо болон муухайг харангуутаа ялгаж байдаг шиг бид харилцааныхаа сайн мууг шууд хэлбэрээр ялгаж байдаг. Энэхүү төрөлхийн ойлголт нь энгийн хялбар, амьдралд үр дүнтэй байдаг хэдий ч ёс суртахууны тухай ойлголтод ямар үнэ цэнэтэй байдаг вэ? Энэ ойлголтоор (intuitive) бол хүний мөн чанарын бус харилцааны хуулийг тогтоох нь гол зорилго болно"⁵⁸ гэсэн байдаг.

Өдөр тутмын харилцааны ёс суртахууны хэм хэмжүүрт энэхүү төрөлхийн ёс суртахууны ойлголтоор үнэн зөв, бодитой, зөрчилгүй ёс суртахууны хуулийг бид гаргаж чадахгүй. Учир нь зарим тохиолдолд бид зөв болон буруугаа буюу сайн муугаа ялгахад төвөгтэй байдалд төөрөлдсөн байдалд ордог. Зөв гэж байсан зүйлс буруу болж, сайн гэж үзэж байсан нь муу болж хувирдаг. Бүх нөхцөлд таарсан ёс суртахууны цорын ганц зөв тодорхойлолт байхгүй хэмээн үүнийгээ тайлбарлажээ. Жишээ нь үнэнч байх, нэр хүндээ хадгалах хоёр бол төрөлхийн үүрэг ч гэсэн энэ хоёрын хооронд зөрчил гарч байдаг. Иймээс бид үнэнч шударга байх, нэр хүндээ хадгалах хоёрын талаар бүрэн дүүрэн мэдэж чаддаггүй.

Цаашилбал, бид ухаалаг байдал, эрэлхэг зориг, тусархаг, бусдын төлөө гэсэн сэтгэл, шударга ёсны талаар талаар ярилцахдаа яг ямар нь жинхэнэ сайныг мэддэггүй, эсвэл эдгээр бүгд сайн эсэхийг ялгахад хүндрэлтэй байдаг. Эдгээрээс бусдад туслах нь сайн мэт боловч хүсээгүй тусламж нь гай гамшигт хүргэдэг тохиолдол байдаг. Бид шударга ёсны тухай их ярьдаг ч яг шударга ёс гэж юугаа хэлээд байгаа гэдгээ сайн мэддэггүй, ойлгодоггүй. Хүн болгон ярьж чаддаг хирнээ биелүүлж чаддаггүй. Үнэхээр юуг шударга гэх вэ? Хүмүүсийг адилтгах нь шударга бус байдаг. Харин хүн бүрийг тус тусад нь үнэлэх нь шударга байдаг. Хүмүүсийг мөн чанараар нь ялгаварлан харилцдаг ч мөн чанар гэж чухам юуг хэлж байна вэ? Бид сайн, мууг шууд ялгах нь учир дутагдалтай, хэрвээ түүнийг ойлгож ухаарахгүйгээр түүнийг ялгавал хүний мөн чанарт дарамт болно хэмээн өөрийн үзлийг тайлбарласан байна.

Эцэст нь дүгнэж хэлбэл, Нишидагийн философи бол дорно болон өрнийн философичид бие биенээ харилцан ойлголцох замаар бие биенийхээ дутууг нөхөх ёстой болохыг харуулсан юм. Тэрээр өөрийн философийг буддизмаас гаралтай дорны философи хэмээн тодорхойлсон боловч японы философийг өрнийн иррациональ философийн агуулгаар баяжуулсан нь түүний философийн үндсэн ойлголтуудаас харагддаг болно.

Ашигласан материал

- Великие мыслители востока. М., 1999
- История современной зарубежной философии. Санкт-Петербург. 1997
- Нишида Китаро. Философский энциклопедический словарь. М., 1989
- Философский энциклопедический словарь. М., 1989
- Kitaro Nishida. An inquiry into the Good. Translated by Masao Abe and Christopher Ives. New Haven Yale University press, 1987
- [<http://plato.stanford.edu/> /Stanford Encyclopedia of Philosophy/]

⁵⁸ Kitaro Nishida. An inquiry into the Good. London. 1987 p104-105